

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 01-Р ХУРАЛ**

Хурлыг 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 цаг 00 минутад эхэлж, 15 цаг 25 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 25 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Ховд аймагт 2015 онд нийтээр тэмдэглэх ой, тэмдэглэлт өдөр, спорт, урлагийн арга хэмжээ, сургалт, зөвлөгөөний нэгдсэн төлөвлөгөө хэлэлцэх тухай	2015 онд нийтээр тэмдэглэх ой, тэмдэглэлт өдөр, спорт, урлагийн арга хэмжээ, сургалт, зөвлөлгөөний нэгдсэн төлөвлөгөө хэлэлцэх явцад гарсан санал, өөрчлөлтүүдийг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Дэлгэрбаярт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 02 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 16 цаг 30 минутад эхэлж, 19 цаг 15 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 2 цаг 45 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн сайн малчин, тэргүүний тариаланч, тэргүүний хоршоо шалгаруулах тухай	1.“Аймгийн сайн малчин” шалгаруулах журмын шаардлага хангасан 16 сумын 29 малчдыг “Аймгийн сайн малчин”-аар шалгуулахаар дэмжив. 2.“Аймгийн тэргүүний тариаланч” шалгаруулах журмын шаардлага хангасан Буянт, Ховд, Эрдэнэбүрэн, Манхан, Мянгад сумдын 5 тариаланчдыг “Аймгийн тэргүүний тариаланч”-аар тус тус шалгаруулахаар шийдвэрлэв.
2	Аймгийн алдарт уяач цол олгох тухай	Уяж уралдуулсан хурдан хүлгүүд нь аймаг, үндэсний наадамд олон удаа түрүү, айраг авч аймгийн алдарт уяачийн болзол хангасан 16 сумын 20 уяачийг аймгийн алдарт уяач цол олгохоор шийдвэрлэв.
3	Сум, байгууллагын ажил дүгнэсэн дүнгийн тухай	Алтай сумыг тэргүүн байрт, Чандмань, сумыг дэд байрт, Буянт сумыг гутгаар байр, Дарви сумыг тусгай байрт, биеийн тамир, спортын газар /хуучнаар Соёл, спорт, аялал жуулчлалын газар/-ыг тэргүүн байрт, Худалдан авах ажиллагааны хэлтсийг дэд байрт, Цагдаагийн газрыг гутгаар байрт, Жаргалант сумын Буянт багийг тэргүүн байрт, Мөст сумын Баянхайрхан багийг дэд байрт, Дарви сумын Мөрөн багийг гутгаар байрт, Дөргөн сумын Өгөөмөр, Зэрэг сумын Хөндлөн багийг тусгай байрт тус тус эзлүүлэхээр хэлэлцэн шийдвэрлэв.
4	МоЭнКо ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтийн тухай	Ажлын хэсгийн ажлыг сайшаагаад 70 хувьтай байна гэж үзээд МоЭнКо ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтийг дүгнэн заалт тус бүрээр нь хувилж гаргаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Эрхбаярт үүрэг болгов.
5	Орон нутгийн 2015 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай	Орон нутгийн 2015 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай төслийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатар үүрэг болгов.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 03 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 14 цаг 30 минутад эхэлж, 15 цаг 05 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 35 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн 9 алдартан шалгаруулах тухай	<p>1.“Аймгийн есөн алдартан”-аар дараах салбарын иргэдийг шалгаруулахаар шийдвэрлэв.Үүнд:</p> <p>1.Боловсролын салбарын алдартан – Баатарсүрэнгийн Ганбаяр /Ерөнхий боловсролын Прогресс дунд сургуулийн математикийн багш</p> <p>2.Эрүүл мэндийн салбарын алдартан – Даваахүүгийн Энхбулган / Мөнххайрхан сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмч /</p> <p>3.Санхүүгийн салбарын алдартан – Аварзэдийн Оюундэлгэр / Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн/</p> <p>4.Барилга, дэд бүтцийн салбарын алдартан – Пүрэвдоржийн Буянжаргал /Ховдын Хаш өргөө ХХК-ний ерөнхий инженер /</p> <p>5.Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын алдартан – Баттөмөрийн Ганхуяг / ХААН авто засварын газар, засварчин /</p> <p>6. Хууль зүйн салбарын алдартан – Бэгзийн Дамба / Иргэний хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүх, шүүгч /</p> <p>7.Соёл, урлагийн салбарын алдартан – Ням-очирын Баасанжав /Ховд ТВ захирал/</p> <p>8.Спортын салбарын алдартан – Содмоогийн Ганхуяг /Аймгийн Биеийн тамир спортын газрын дасгалжуулагч /</p> <p>9.Байгаль орчин, ногоон бизнесийн салбарын алдартан – Гэндэнгийн Сайнбилэг /Дэлхийн зөн ОУБ-ын ажилтан /</p>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗӨВЛӨЛИЙН 04 ДУГААР ХУРАЛ**

Хурлыг 2015 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14 цаг 20 минутад эхэлж, 16 цаг 25 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 2 цаг 05 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Орон нутгийн концессын зүйлийн жагсаалтын тухай	Орон нутгийн концессын зүйлийн жагсаалт хэлэлцэх явцад гарсан санал, өөрчлөлтүүдийг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч Ч.Чинбатад үүрэг болгов.
2	Мөнххайрхан сумын Соёлын төвийг Төрийн соёрхолт урианхайн алдарт туульч Баатарын Авирмэдийн нэрэмжит болгох тухай	Мөнххайрхан сумын Соёлын төвийг Төрийн соёрхолт урианхайн алдарт туульч Баатарын Авирмэдийн нэрэмжит болгох тухай саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч Ч.Чинбатад үүрэг болгов.
3	Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний 2014 оны тайлан	Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний 2014 оны тайланг санал нэгтэй дэмжиж хугацаанд нь ЗГХЭГ-т хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний тасгийн дарга Ц.Оюунцэцэгт үүрэг болгов.
4	Төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжид өгөх хэрэглэгчийн үнэлгээний тайлан	Төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжид өгөх хэрэглэгчийн үнэлгээний дагуу гарсан зөвлөмж, гарсан саналын дагуу ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээний тасгийн дарга Ц.Оюунцэцэгт үүрэг болгов.
5	“Архидан согтуурахтай тэмцэх сан”-ийн журмын төсөл	Сан байгуулахгүйгээр 5 хүний бүрэлдхүүнтэй ажлын хэсэг байгуулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихыг Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Оюунцэцэгт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР